

СПОРТЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
Ж.БААСАНСҮРЭНГИЙН 2025 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС
(УДИРДАХ АЛБАН ТУШААЛТАН БУЮУ НЭГЖИЙН ДАРГА)

Байгууллагын нэр: ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ БИЕИЙН ТАМИР,
СПОРТЫН УЛСЫН ХОРОО

Нэгжийн нэр: СПОРТЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ХЭЛТЭС

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Нийт (70 оноо)
1	2	3	4
0	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	Биелэлтийн хувь = (Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн хувь)	(Биелэлтийн хувь * 70 / 100%)
	Зорилт 1.1. Хүн амын бие бялдрын хөгжлийн түвшнийг хянах сорилын төвийг аймаг, дүүрэг бүрд байгуулж, дата өгөгдөлд дүн шнжилгээ хийх хүчин чадлыг сайжруулах, бие бялдрын хөгжлийн сорилын суурь үзүүлэлт, идэвхтэй хөдөлгөөн, спортын талаарх мэдлэг, хандлага, дадлыг нэмэгдүүлэх		
1	Арга хэмжээ-1.1.1 Монгол Улсад зохион байгуулах олон улсын биеийн тамир, спортын арга хэмжээнд олон улсын спортын протоколын дагуу дэмжлэг үзүүлэх зэрэг санал өгсөн.	100	70
	Зорилт 2.1. Монгол Улсад зохион байгуулах олон улсын тэмцээний тоо, үр ашгийг нэмэгдүүлэх, спортын сургалт дасгалжуулалтын үр дүнг сайжруулах, спортын авьяасыг нээн илрүүлж, өрсөлдөхөд чадварыг дээшлүүлэх, допингийн эсрэг үйл ажиллагааг эрчимжүүлэх		
2	Арга хэмжээ 2.1.1 Цахим мэдээллийн санд үндэсний шигшээ багийн бус спортын холбоод, наадам, тэмцээн, арга хэмжээний талаарх 11 мэдээллийг байршуулсан.	100	70
3	Арга хэмжээ 2.1.2 БТСтХуулийн дагуу 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн спортын холбоодоос тамирчдад спортын цолыг олгож эхэлсэн бөгөөд Биеийн тамир, спортын цахим системд шивэгдээгүй спортын цол хүртсэн 28 спортын төрлийн 592 тамирчин, шүүгчдийн мэдээллийг нэгтгэж, өгөгдлийг бүрдүүлж, и баяжилт хийсэн.	100	70
4	Арга хэмжээ 2.1.3 Монголын хүүхдийн спортын өвлийн VIII наадам, Монголын хүүхдийн спортын зуны VIII наадам, Монголын бүх ард түмний спортын зуны XVI наадмын нэгдсэн заавар, сайдын мэндчилгээ, зохион байгуулах хорооны бүрэлдэхүүн, тэмцээний хуваарь, зохион байгуулалт, оролцогч баг, тамирчдын цахим бүртгэл, наадмын танилцуулга, тэмцээний үр дүнгийн мэдээ, мэдээллийг байршуулж сурталчилсан.	100	70
5	Арга хэмжээ 2.1.4 Монголын хүүхдийн спортын өвлийн VIII наадмыг Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 183 дугаар	100	70

	тогтоолын хавсралтаар батлагдсан "Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах журам"-ын хүрээнд Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны А/09, А/16, А/17 дугаар тушаал батлагдаж, шигшээ тэмцээний зохион байгуулалтын зардалд 299,980,000 төгрөг баталсан. Ажил гүйцэтгэх 14 удаагийн гэрээг байгуулж, гүйцэтгэлийг хангуулсан. Тус наадам нь "Мөрөөдлийнхөө төлөө шударгаар өрсөлдье" гэсэн уриан дор Галхүү нэртэй билэгдэлтэй, цэнхэр өнгийг үндсэн өнгөөр сонгосон. Хүүхдийн өвлийн 8 наадамд спортын 8 төрлийн 80 зай, ангилалд аймаг, дүүргийн 22 байгууллагын 11-17 хүртэлх насны өсвөрийн шилдгийн шилдэг 546 өсвөрийн тамирчид 478 медалийн төлөө Улаанбаатар хотын Хандгайтын мөсөн талбай (тэшүүр, шорт трейк), Чингэлтэй дүүргийн мөсөн талбай (шайбтай хоккей) болон Орхон аймгийн Сархиа цанын бааз (гүйлтийн цана, тусгай гүйлтийн цана, цасны гуталтай гүйлт, уулын цана, снөүбоард)-д тус тус өрсөлдсөн. Байгууллагын нэгдсэн дүнгээр аймгуудаас Хөвсгөл аймгийн баг 20 алт, 21 мөнгө, 20 хүрэл буюу нийт 61 медальтайгаар тэргүүн байрт, дүүргүүдээс Баянзүрх дүүргийн баг 8 алт, 2 мөнгө, 12 хүрэл буюу нийт 22 медальтайгаар тэргүүн байрт шалгарч цом, медаль, мөнгөн урамшууллаар шагнагдсан. Монголын хүүхдийн спортын өвлийн VIII наадмын нэгдсэн хөтөлбөрт багтсан үндсэн 7 спортын төрөлд амжилттай оролцож медальт байрт шалгарсан 371 тамирчин, 21 дасгалжуулагч, нийт 392 хүнд Засгийн газрын 2018 оны 173 дугаар тогтоолоор 160,000,000 төгрөгийг БТСУХорооны даргын тушаалаар олгосон. Наадмын шигшээ тэмцээний шууд дамжуулалт, мэдээ, сурвалжлага, нэвтрүүлгийг МҮОНРТелевизийн үндсэн суваг, MNB спорт суваг мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэж олон нийтэд сурталчилсан.		
6	Арга хэмжээ 2.1.5 Монголын хүүхдийн спортын зуны VIII наадмыг Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нэгдсэн зааврыг БТСУХорооны даргын 2025 оны А/45 дугаар тушаалаар баталж, шигшээ тэмцээнд 9-17 насны өсвөрийн 6120 тамирчид 286 багц медалийн төлөө Улаанбаатар хотноо 2025 оны 05 дугаар сарын 26-наас 06 дугаар сарын 05-ны хугацаанд 7 дүүргийн 19 байршилд нэгэн зэрэг спортын 31 төрлөөр өрсөлдсөн. Байгууллагын нэгдсэн дүнгээр 30 байгууллагаас өрсөлдсөнөөс Хан-Уул дүүргийн баг 36 алт, 27 мөнгө, 26 хүрэл, нийт 89 медальтай тэргүүлж, Сүхбаатар (66 медаль), Чингэлтэй (59 медаль) дүүргийн баг удааллаа. Аймгуудаас Орхон аймгийн баг 15 алт, 15 мөнгө, 25 хүрэл, нийт 55 медальтай тэргүүлж, Дархан Уул (47 медаль), Хөвсгөл (40 медаль), Өвөрхангай (36 медаль), Дорнод (28 медаль), Сэлэнгэ (27 медаль) аймгууд эхний 6 байрт, мөн хөгжлийн бэрхшээлтэй спортын төрөлд 16 байгууллага өрсөлдсөнөөс Баянгол (13 медаль), Сүхбаатар (9 медаль) дүүргүүд, Дархан Уул аймаг (7 медаль) эхний 3 байрт тус тус шалгарч наадмын цом, мөнгөн шагнал,	100	70

	өргөмжлөлөөр шагнагдсан. МҮОНРТ-ийн MNB sport сувгаар наадмын нээлт, хаалтын ажиллагаа, шигшээ тэмцээний 10 спортын төрлийн тэмцээнийг шууд дамжуулж, БТСУХорооны пэйж хуудас, вэб сайтаар 100 ширхэг гэрэл зураг, мэдээ, рийл бичлэг 87, ярилцлага, 44 постер хийж сурталчилгааг байршуулахад 12 хоногийн хугацаанд 5 сая гаруй үзэлттэй, 99119 реакшин, 8192 комент үзүүлж, Биеийн тамир спортын улсын хорооны пэйж хуудсыг дагасадын тоо 4000 хүнээр нэмэгдсэн.			
7	Арга хэмжээ 2.1.6 Монголын бүх ард түмний зуны спортын XVI наадмын Зохион байгуулах хорооны бүрэлдэхүүнийг БТСУХорооны даргын 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн А/192 дугаар тушаалаар байгуулж, шигшээ тэмцээнийг 2025 оны есдүгээр сарын 15-21-ний өдрүүдэд Улаанбаатар хот, Баянхонгор аймагт нэгэн зэрэг 20 байршилд нэгэн зэрэг зохион байгуулахад Даргын 2025 оны А/250 тушаалаар улсын төсвөөс 261,229,448 төгрөг батлагдсан. Баянхонгор аймгийн орон нутгийн төсвөөс 230 сая төгрөгийн санхүүжилт гарсан. Ажил гүйцэтгэх 26 гэрээг мэргэжлийн спортын холбоотой байгуулж, гүйцэтгэлийг хангуулсан. Наадамд 30 байгууллагын 329 дасгалжуулагч, 3258 тамирчин хамрагдан 879 багц медалийн төлөөх өрсөлдөөнийг 425 шүүгч дэнслэн ажиллав. Баянхонгор аймагт спортын 17 төрлийн тэмцээнийг 13 байршилд зохиоход 2150 тамирчин, 243 дасгалжуулагч, 294 шүүгч ажиллаж, мөн Улаанбаатар хотод спортын 11 төрлийн тэмцээнийг 7 байршилд зохиоход 1108 тамирчин, 86 дасгалжуулагч, 131 шүүгч ажилласан.	100		70
8	Арга хэмжээ 2.1.7 Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах журам”-ын хүрээнд Засгийн газрын 2025 оны 243 дугаар тогтоол 2025,05,21-ний өдөр 11 тэмцээнийг зохиохоор баталгаажсан. Үүнээс 2 тэмцээн цуцлагдаж, 1 тэмцээний нэр зөрсөн тул санхүүжилт гаргаагүй. Нийт зохиогдсон 8 тэмцээнд 2,887,229,820 төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгосон. 1-2/. Монголын бильярдын холбооноос Олон улсын холбооны тэмцээн цуцлах хүсэлтийг уламжилсан албан бичгийн дагуу “Снукер бильярдын ДАШТ”-ийг, мөн Монголын гимнастикийн холбооноос тэмцээн цуцлуулах саналыг албан бичгээр ирүүлсэнээр 2 тэмцээн цуцлагдсан. 3/. Чөлөөт бөхийн дэлхийн чансаа олгох “Улаанбаатар опен” олон улсын тэмцээнийг Улаанбаатар хотноо 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрөөс 06 дугаар сарын 01-ний өдрүүдэд зохиоход Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны А/162 дугаар тушаалаар 1,039,500,000 төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр баталж, Дэмжлэг үзүүлэх 2025 оны 142 дугаар гэрээг байгуулж, гүйцэтгүүлсэн. Тэмцээн Буянт Ухаа спорт цогцолборт зохиогдож 23 орны албаны хүн, шүүгчид, төлөөлөгчид хүрэлцэн ирж, тэмцээнд 30 орны 300 гаруй тамирчид оролцсон.	100		70

4/Жүдо бөхийн "Улаанбаатар их дуулга 2025" олимпын эрхийн оноо олгох, дэлхийн чансааны оноо олгох тэмцээнийг Улаанбаатар хотноо 2025 оны 07 дугаар сарын 25-27-ны өдрүүдэд "Степп Арена" спорт цогцолборт зохиоход Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны А/214 дүгээр тушаалаар 1,499,500,000 төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр баталж, Дэмжлэг үзүүлэх 2025 оны 175 дугаар гэрээг байгуулж, гүйцэтгүүлсэн. Тэмцээнд Тэмцээнд 5 тив, 30 орны 236 тамирчид эрэгтэй, эмэгтэй тус бүр 7-н жинд өрсөлдсөн.

5/. Электрон спортын "Номадик Мастерс" олон улсын тэмцээн 2025 оны 04 дүгээр сарын 30-наас 05 дугаар сарын 04-ний өдрүүдэд Улаанбаатар хот ASA Arena-д зохиогдоход Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны А/261 дүгээр тушаалаар 38,258,000 төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр баталж, дэмжлэг үзүүлэх 2025 оны 192 дугаар гэрээг байгуулж, гүйцэтгүүлсэн. Тэмцээнд 11 орны 457 тамирчид хамрагдсан.

6/. Спорт авто машины "Экстрим, энтертаймент 2025" олон улсын тэмцээн 2025 оны 05 дугаар сарын 09-11-ны өдрүүдэд Улаанбаатар хот ASA Arena- амжилттай зохиоход Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны А/260 дугаар тушаалаар 38,566,250 төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр баталж, Дэмжлэг үзүүлэх 2025 оны 191 дүгээр гэрээг байгуулж, гүйцэтгүүлсэн. Тэмцээнд 7 орны 110 тамирчид хамрагдсан.

7/Сонгодог дартсын "Дартс фестиваль-2025" олон улсын тэмцээн 2025 оны 05 дугаар сарын 15-18-ны өдрүүдэд Улаанбаатар хот Их наяд плазад зохиогдоход Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны А/259 дүгээр тушаалаар 34,258,000 төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр баталж, дэмжлэг үзүүлэх 2025 оны 194 гэрээг байгуулж, гүйцэтгүүлсэн. Тэмцээнд 14 орны 70 гаруй тамирчид хамрагдсан.

8/. Дуатлоны ази тивийн цомын аварга шалгаруулах тэмцээн 2025 оны 9 дүгээр сарын 05-06 ны өдрүүдэд Улаанбаатар хот Монгол наадам цогцолбор, Хүй долоо худагт зохиогдоход Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны А/262 дугаар тушаалаар 97,147,570 төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр баталж, Дэмжлэг үзүүлэх 2025 оны 193 гэрээг байгуулж, гүйцэтгүүлсэн. Тэмцээнд 4 орны 90 гаруй тамирчид хамрагдсан.

9/. Жюү жицүгийн "Улаанбаатар про 2025" 7 дахь удаагийн тэмцээн 2025 оны 10 дугаар сарын 02-05-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдахад Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны А/308 дугаар тушаалаар 40,000,000 төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр баталж, Дэмжлэг үзүүлэх 2025 оны 253 гэрээг байгуулж, гүйцэтгүүлсэн.

10/. Шатрын сурагчдын Ази тийн аварга шалгаруулах тэмцээн Улаанбаатар хотноо 2025 оны 10 дугаар сарын 24-нөөс 11 дүгээр сарын 02-ны өдрүүдэд зохиогдоход Биеийн тамир, спортын улсын хорооны

	даргын 2025 оны А/313 дугаар тушаалаар 100,000,000 төгрөгийг баталж, Дэмжлэг үзүүлэх 2025 оны 254 дүгээр гэрээ байгуулж, гүйцэтгүүлсэн. Тэмцээнд 16 орны 700 орчим тамирчид, 6 насны ангилалд оролцсон. 11/.Морьт харвааны Ази тивийн аварга шалгаруулах тэмцээний НЭР зөрсөн тул санхүүжилт гаргаагүй.			
9	Арга хэмжээ 2.1.8 Тусгай Олимпын тамирчдыг олон улсын “3х3 хамтарсан сагсан бөмбөг”-ийн Тусгай Олимпын Зүүн Азийн бүсийн аварга шалгаруулах тэмцээнд оролцоход Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/163 дугаар тушаалаар 12,283,200 төгрөгийн санхүүжгийн дэмжлэг үзүүлэхээр баталж, Дэмжлэг үзүүлэх 2025 оны 148 гэрээг байгуулж, гүйцэтгүүлсэн. Тэмцээн Бүгд Найрамдах Солонгос Улсын КангВон-До хотноо 2025 оны 06 дугаар сарын 27-29-ний өдрүүдэд зохиогдоход 3 тамирчин, 2 дэмжин тоглогч, 1 багийн ахлагч, 1 багийн дасгалжуулагч, нийт 7 хүн оролцсон.	100		70
10	Арга хэмжээ 2.1.9 Биеийн тамир, спортын экспо 2025 үзэсгэлэн зохион байгуулах ажлын хүрээнд М Банк аренад 2025 оны 09 дүгээр сарын 18-19-ний өдрүүдэд зохиогдсон үзэсгэлэнд спортын холбоодыг өргөнөөр хамруулсан.	100		70
11	Арга хэмжээ 2.1.10 Монгол Улсын Засгийн газар, ССАЖЗЯмнаас хэрэгжүүлж буй “Go Mongolia” үндэсний брэндийн хүрээнд Монгол Улсын хөл бөмбөгийн шигшээ багийн тамирчдыг бэлтгэх, хөл бөмбөг сонирхогч хүүхэд залууст урам зориг өгөх, спортоор хичээллэх сэдэл өгөх зорилгоор Английн мэргэжлийн Хөлбөмбөгийн Примьер лигийн Фулхэм клубийн сургалтад өсвөрийн 11 тамирчдыг 2025,04,02-07-ны өдрүүдэд хамруулсан. Хөлбөмбөгийн тамирчид 04 дүгээр сарын 06-ны өдөр Фулхэм VS Ливерпүүл тоглолтыг урилгаар үзсэн.	100		70
12	Арга хэмжээ 2.1.11 Биеийн тамир, спортын чиглэлд төрийн зарим чиг үүргийг 25 гэрээний дагуу төрийн бус байгууллагад шилжүүлэн 982,837,745 төгрөгийн дэмжлэг үзүүлж, түр ажлын байр бий болгон 26 удаагийн үйл ажиллагааг гүйцэтгүүлсэн. Үүнд: * Бусад спортыг дэмжих зардлаас Үндэсний шигшээ багийн бус спортын төрлийн уралдаан, тэмцээн, сургалт, үйл ажиллагаанд оролцох зохион байгуулахад Даргын 25 тушаалаар 888,337,745 төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 24 гэрээгээр гүйцэтгүүлсэн. * Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх зардлаас Даргын 1 тушаалаар 1 ажлыг 94,500,000 төгрөгийн зардлыг баталж, 1 гэрээгээр гүйцэтгүүлсэн.	100		70
	Зорилт 3.1. Нүүдэлчдийн спортын өв, соёл болсон үндэсний уламжлалт спортын наадмын шинжлэх ухааны судалгааны ажлыг өргөжүүлэх, үндэсний спортын төрлийн олон улсын тэмцээн, наадмыг нэмэгдүүлэх, орон нутгийн бренд арга хэмжээг бий болгох ажлыг эрчимжүүлнэ (дотоодын аялал жуулчлалыг дэмжих)			

13	Арга хэмжээ 3.1.1. Монгол Нүүдэлчин өвлийн фестивалийн зохион байгуулалтад даргын 2025 оны А/28 дугаар тушаалаар 19,885,000 төгрөг, А/35 дугаар тушаалаар 60 сая төгрөг, нийт 79,885,000 төгрөгийн дэмжлэг үзүүлж, Монголын Үндэсний спортын хороотой хамтран Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд 2025 оны 02 дугаар 16-23-ны өдрүүдэд үндэсний спортын 2 төрөлд 12 тэмцээнийг зохион байгуулахад 303 тамирчин, морин аялалд 190 орчим хүмүүс морь унаж оролцсон. 2/. 2025 оны 08 дугаар сарын 22-24-ний өдрүүдэд Налайх дүүрэгт зохион байгуулагдсан "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестиваль"-ийн хүрээнд зохиогдсон Үндэсний бөхийн барилдаан, сур харваа, шагайн наадгай, хурдан морины уралдаан зэрэг тэмцээнд 447, гадаадын 23, дотоодын 176 оролцогч нийт 645 хүн хамрагдсан. Монголын Үндэсний бөхийн холбооноос 18 хүн, Монголын үндэсний харваачдын холбооноос 16 хүн, Монголын шагайн харваан холбооноос 8 хүн, Монголын үндэсний морин уралдаан уяачдын холбооноос 8 хүн, Монголын адуучдын холбооноос 6 хүн, ерөнхий зохион байгуулалтад 4, нийт 60 хүн ажилласан	100	70
14	Арга хэмжээ 3.1.2 Бүгд Найрамдах Казакстан улсын Шымкент хотноо 2025 оны 06 дугаар сарын 04-06-ны өдрүүдэд зохион байгуулагдах Зоос шүүрэх(Тенге илу)-ийн дэлхийн анхны аварга шалгаруулах тэмцээнд оролцох баг, бүрэлдэхүүнд Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны А/152 дугаар тушаалаар 7,700,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Тэмцээнд 6 тамирчин оролцож 2 мөнгө, 1 хүрэл медаль хүртсэн амжилт гаргасан.	100	70
15	Арга хэмжээ 3.1.3 1/. Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны Хайчийн аманд Өвлийн аялал аялал жуулчлалын хамгийн том эвент "Хөх сувд 2025" олон улсын мөсний баяр 2025 оны 02 дугаар сарын 13-23-ны өдрүүдэд 24 дэх жилдээ зохион байгуулагдаж тэшүүр, мөсөн дээрх буухиа тэмцээн, мөсөн волейболын тэмцээн, урлагийн тоглолт 4 төрлийн тэмцээн уралдааныг Хөвсгөл аймгийн ЗДТГ, Хөвсгөл аймгийн БТСГазар хамтран зохион байгуулахад 380 тамирчин хамрагдсан. 2/.Сэлэнгэ аймгийн Ерөө суманд 3 дахь жилдээ "Ерөө CUP 2025" Мөсөн сурын харвааны олон улсын нээлттэй тэмцээн эвэнт арга хэмжээ 2025 оны 02 дугаар сарын 08-09 өдрүүдэд зохион байгуулагдаж Монгол, Буриад улсын 20 багийн 200 гаруй тамирчин оролцсон. 3/.Ховд аймгийн Биеийн тамир, спортын газар, Монголын мөсний шагайн холбоотой хамтран Буянт гол дээр Мөсөн шагайн харваан онол, практикийн сургалтад даргын 2025 оны А/10 дугаар тушаалаар 9,750,000 төгрөгийн дэмжлэг үзүүлж, 2025 оны 02 дугаар сарын 08-09-ний өдрүүдэд зохион байгуулахад 6 байгууллагын 41 оролцогч хамрагдсан.	80	56

	4/Үндэсний спортын төрлөөр хичээллэгчид, оролцсон тэмцээн, зохион байгуулсан тэмцээн, арга хэмжээний талаарх судалгааг 21 аймаг, 9 дүүргээс авч нэгтгэсэн.			
	Зорилт 4.1.Өвлийн спорт болон үндэсний шигшээ багийн нөөц тамирчдыг бэлтгэх ажлын хүрээнд өсвөр, залуучуудын ангиллын тамирчдын амжилтыг ахиулахад чиглэсэн цогц арга хэмжээ хэрэгжүүлэх			
16	Арга хэмжээ 4.1.1 Олимп, паралимпын наадам, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс олимпийн жин, зайд медаль хүртсэн 11 спортын төрлийн 78 тамирчинд 2025 онд олгох Сар бүрийн мөнгөн урамшууллын хэмжээ, тамирчдын нэрсийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны А/31 дүгээр тушаалаар 2,130,000,000 төгрөгийг (сард 177,500,000 төгрөг, улиралд 532,500,000 төгрөг, жилд 2,130,000,000 төгрөг) шийдвэрлүүлэн олгосон.	100		70
17	Арга хэмжээ 4.1.2 Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 173 дугаар тогтоолын дагуу Нэг удаагийн мөнгөн шагнал олгохоор БТСУХорооны даргын 2025 оны А/130, А/219, А/299, А/352 дугаар тушаал батлагдаж, нийт 3248 хүнд 2,427,700,000 төгрөг олгогдоно. 1/. Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны А/130 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар “Монголын хүүхдийн спортын өвлийн VIII наадамд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчдын нэрсийн жагсаалт, нэг удаагийн мөнгөн шагналын хэмжээ”-г баталж, өвлийн үндсэн 7 спортын төрөлд медальт байрт шалгарсан 371 тамирчин, 21 дасгалжуулагч, нийт 392 хүнд нэг удаагийн 160,000,000 төгрөгийн нэг удаагийн мөнгөн шагнал олгогдсон. 2/. Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны А/130 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар “Олимп, олимпын бус төрлийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчдын нэрсийн жагсаалт, нэг удаагийн мөнгөн мөнгөн шагналын хэмжээ”-г баталж, 49 хүнд 146,370,000 төгрөгийн нэг удаагийн мөнгөн шагнал олгогдсон. 3/. Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны А/219 дүгээр тушаалаар Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож медаль хүртсэн 4 спортын төрлийн 23 тамирчин, 7 дасгалжуулагчдад 269,730,000 төгрөгийн нэг удагийн мөнгөн шагнал олгогдсон. 4. Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны А/299 дүгээр тушаалаар Монголын хүүхдийн спортын зуны VIII наадамд оролцож медаль хүртсэн 28 спортын төрлийн 1461 тамирчин, дасгалжуулагчдад 564,600,000 төгрөгийн нэг удаагийн мөнгөн шагнал олгогдсон. 5. Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны А/352 дугаар тушаалаар Монголын бүх ард түмний спортын XVI наадамд амжилттай оролцож медаль хүртсэн 28 спортын 1217 тамирчин, 99 дасгалжуулагчид, нийт 1316 хүнд олгох нэг удаагийн мөнгөн шагнал болох 1,287,000,000 төгрөгийг	100		70

	батласан бөгөөд санхүүжилт 2025,12,04-ний өдрийн байдлаар хүлээгдэж байна.			
18	Арга хэмжээ 4.1.3 Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн А/294 дугаар тушаалаар 80,622,497,05 төгрөгийг баталж, спортын 9 холбоотой Дэмжлэг үзүүлэх гэрээг байгуулж, гүйцэтгүүлсэн. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах орны Бугат, Баяннуур хотноо 2025 оны 09 дүгээр сарын 21-28-ны өдрүүдэд зохиогдсон “Олон улсын хүүхдийн XI наадам”-д Монгол Улсын баг спортын 9 төрөлд 125 тамирчид 21 дасгалжуулагчийн удирдлага дор оролцон 112 тамирчин алт, мөнгө, хүрэл медаль хүртсэн бөгөөд багийн хүртсэн медалийг 1 ширхэг медалиар тоолбол нийт 58 медаль (32 алт, 16 мөнгө, 10 хүрэл) хүртэн бахдам амжилтыг үзүүлсэн. Тус наадамд 3 орны 826 тамирчин хамрагдсан. Спортын 9 холбоотой гэрээ байгуулж ажилласан. Тус наадамд 3 орны 826 тамирчин хамрагдсан.	100		70
19	Арга хэмжээ 4.1.4 "Турино 2025" Дэлхийн оюутны өвлийн универсиад наадамд цана, снөүбоардын төрөлд оролцсон 11 хүний замын зардалд БТСУХорооны даргын 2025 оны А/28 дугаар тушаалаар 48,482,700 төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж, тамирчид тэмцээнд амжилттай оролцсон.	100		70
20	Арга хэмжээ 4.1.5 "Турин-2025" Дэлхийн тусгай олимпын наадамд Үндэсний шигшээ багийн бус тамирчдыг оролцоход дэмжлэг үзүүлэх Бүгд Найрамдах Итали Улсын Турин хотноо 2025 оны 03 дугаар сарын 08-16-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Турин-2025" Дэлхийн тусгай олимпын наадамд Монгол Улсаа төлөөлөн оролцох оролцох 25 тамирчин, 9 дасгалжуулагч, 1 эмч, нийт 35 хүнд даргын 2025.02.24-ны өдрийн А/37 дугаар тушаал, 2025.02.27-ны өдрийн 38 дугаартай гэрээний дагуу 115,832,710 төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж, наадам 2025 оны 03 сарын 8-16-ны өдрүүдэд зохиогдоход баг тамирчид 5 алт, 10 мөнгө, 6 хүрэл медаль, нийт 21 медаль хүртсэн.	100		70
21	Арга хэмжээ 4.1.6 Харбин 2025 Азийн өвлийн спортын IX наадамд оролцоход дэмжлэг үзүүлэх БНХАУ-ын Харбин хотноо 2025 оны 02 дугаар 06-14-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Харбин 2025 азийн өвлийн спортын IX наадамд байгууллагын удирдлагыг оролцуулахад БТСУХорооны даргын 2025 оны А/25 тушаалаар 5,485,000 төгрөгийг, Монгол Улсын багийн штаб, хэвлэл мэдээлэл, сурвалжлага хийх, эмчийн бүрэлдэхүүнийг ажиллуулахад БТСУХорооны даргын 2025 оны А/11 дүгээр тушаалаар 12,588,400 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Томилогдсон баг үүргээ амжилттай биелүүлсэн.	100		70
Зорилго 5. Спортын сургалт дасгалжуулалтад шинжлэх ухааны дэвшилтэд арга зүйг нэвтрүүлж, сургалт судалгаа шинжилгээ хийх,суурь нөхцөл бүрдсэн байх				

22	Арга хэмжээ 5.1 Спортын холбоодыг дэмжих, шинэ спортын төрлийг сурталчлах 6 үйл ажиллагааг зохиосон. 1/.Монголын сагсан бөмбөгийн дасгалжуулагчдын холбоо, Монголын сагсан бөмбөгийн холбоод хамтран “COACH CLINIC” хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалтыг 2025 оны 03 дугаар сарын 20-21-ний өдрүүдэд Сүхбаатар аймгийн Баруун-Урт хотод зохион байгуулахад Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгийн 124 сурагч, 54 дасгалжуулагч хамрагдсан. 2/. Монголын сагсан бөмбөгийн дасгалжуулагчдын холбоо, Монголын сагсан бөмбөгийн холбоод хамтран “COACH CLINIC” хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалтыг 2025 оны 04 дүгээр сарын 03-04-ний өдрүүдэд Өмнөговь аймгийн Даланзадгад хотод зохион байгуулахад Дундговь аймгийн 104 сурагч, дасгалжуулагч хамрагдсан. 3/. Монголын спортын сэтгэл судлаачдын холбооноос 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдөр Дундговь аймгийн 80 гаруй багш, дасгалжуулагч, сурагчдад спортын сэтгэл зүйн сургалт зохион байгуулав.Сургалтыг Монголын спортын сэтгэл судлаачдын холбооны сургалт хөгжүүлэлтийн албаны дарга М.Энхцэцэг, сэтгэл зүйч Б.Батчимэг нар удирдан явуулав. 4/.Хүүхдийн спортын өвлийн VIII наадмын хөтөлбөрт цасны гуталтай гүйлтийн төрлийг сурталчилж, дэмжлэг үзүүлсэн. 5/.Мэргэжлийн сумо бөхийн холбоо, Муайтай спортын холбоо, Автомашин мотоциклийн холбоо, Дрифт сонирхогчдын холбоо, Электрон спортын холбоо зэрэг 5 спортын холбоодод мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлсэн. 6/.Монголын сагсан бөмбөгийн холбооноос зохион байгуулж буй “Сурагчийн лиг 2025-2026” сагсан бөмбөгийн тэмцээний удирдамжийг батлуулж 21 аймаг, 9 дүүргийн Биеийн тамир, спортын байгууллагуудад даргын 2025 оны 1/956 дугаар албан бичгээр хүргүүлж оролцоог ханган ажилласан.	80		56
23	Арга хэмжээ 5.2 <i>Улсын аварга шалгаруулах 21 төрлийн тэмцээнд 538 багийн бага нас, өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчид, ахмад насны ангилалд 12960 тамирчид хурд хүч, авхаалж самбаагаа өрсөлдсөн.</i> 1/.Мөсөн сурын харвааны насанд хүрэгчдийн багийн болон хувийн цуваа харвааны (эрэгтэй) УАШТэмцээнд 54 багийн 660 тамирчин; 2/.Мөсөн шагайн харвааны УАШТэмцээнийг 4 насны ангиллаар зохиоход 372 тамирчин; 3/.Бадминтоны УАШТэмцээнийг 3 насны ангиллаар зохиоход 751 тамирчинд 4/.Боксын залуучуудын УАШТэмцээнд 31 багийн 340 тамирчин; 5/.Модон барилдааны УАШТэмцээнийг 2 насны ангиллаар зохиоход 520 тамирчин; 6/.Пауэрлифтингийн УАШТэмцээнийг 2 насны ангиллаар зохиоход 19 аймаг, 9 дүүргийн 420 тамирчин;	80		56

	7/.Туялзуур сэлэмний УАШТэмцээнийг 2 насны ангиллаар зохиоход 100 тамирчин; 8/.Самбо бөхийн УАШТэмцээнийг 6 насны ангиллаар зохиоход 30 багийн 300 тамирчин; 9/.Таеквондогийн УАШТэмцээнийг 5 насны ангиллаар зохиоход 106 багийн 1264 тамирчин; 10/.Чөлөөт бөхийн УАШТэмцээнийг 5 насны ангиллаар зохиоход 58 багийн 1106 тамирчин; 11/.Ширээний теннисний УАШТэмцээнийг 5 насны ангиллаар 30 багийн 704 тамирчин; 12/.Олон улсын таеквондогийн УАШтэмцээнийг 2 насны ангиллаар зохиоход 29 багийн 804 тамирчин; 13/.Жюү жицүгийн УАШТэмцээнийг 3 насны ангиллаар зохиоход 1065 тамирчин; 14/.Бүстэй бөхийн барилдааны УАШТэмцээнийг 3 насны ангиллаар зохиоход 650 тамирчин; 15/.Усанд сэлэлтийн УАШТэмцээнийг 3 насны ангиллаар зохиоход 43 багийн 724 тамирчин; 16/.Хүндийн өргөлтийн УАШТэмцээнийг 2 насны ангиллаар зохиоход 20 багийн 190 тамирчин; Хоккейн УАШтэмцээнийг 5 насны ангиллаар зохиоход 51 багийн 934 тамирчин; 17/.Билльярдын УАШТэмцээнийг 3 насны ангиллаар зохиоход 200 тамирчин; 18/. Даамын УАШТэмцээнийг 2 насны ангиллаар зохиоход 41 багийн 810 тамирчин; 19/.Шатрын УАШТэмцээнийг 2 насны ангиллаар зохиоход 940 тамирчин; 20/.Пара бадминтоны УАШТэмцээнд 5 багийн 26 тамирчин; 21/.Пара бочигийн УАШтэмцээнд 12 багийн 80 тамирчин 22/.Дрифт: 2024 оны фестивальд 3 улсын 30 мэргэжлийн тамирчин, нийт сонирхогч 68 оролцож, 26,000 үзэгч үзсэн бол 2025 оны фестивальд 8 улсын 110 мэргэжлийн тамирчин оролцож 43,000 үзэгч үзсэн гэсэн судалгааны тоон үзүүлэлт гарсан. 2025 оны 05 сарын 09-11-нд Улаанбаатар хотноо 13 дахь удаагийн "Power expo & festival 2025" Монголын анхны автомашин мотоциклийн олон улсын наадам Монгол улсад анх удаа автомашин мотоциклийн төрлөөр зохиогдож БНХАУ, АНУ, ОХУ, БНСУ, Япон, Казахстан, Киргизстан зэрэг 7 орны 110 тамирчин өрсөлдөж, БНХАУ-н багийн болон хувь тамирчид тэргүүн байрт шалгарсан. 23/. Бүгд Найрамдах Социалист Вьетнам улсад 2025 оны 06 дугаар сарын 20-26-нд зохиогдох Азийн аварга шалгаруулах Муайтайн тэмцээнд оролцох 6 тамирчин, 1 дасгалжуулагч, 1 шүүгч, багийн бүрэлдэхүүнд дэмжлэг үзүүлсэн. 24/.Монголын хүүхдийн спортын өвөл, зуны наадмын спортын төрлийн судалгааг 2023 онд зохион байгуулсан наадамд оролцсон тамирчин, спортын төрөлтэй харьцуулж, судалгааны үндсэн 2025 оны наадмыг зохион байгуулсан.		
24	Арга хэмжээ 5.3 Үндэсний спортоор хичээллэгчдийн дэлгэрэнгүй судалгааг тоо, нас, хүйсний ангиллаар Аймаг, орон	100	70

	нутагт үйл ажиллагаа явуулдаг үндэсний спортын төрлүүд, нас, хүйсний ангиллаар гаргах судалгааны маягт боловсруулж, Үндэсний спортын төрлөөр хичээллэгчид, оролцсон тэмцээн, зохион байгуулсан тэмцээн, арга хэмжээний талаарх судалгааг 21 аймаг, 9 дүүргээс авч нэгтгэсэн.			
25	Арга хэмжээ 5.4 Багийн спортын төрөлд Дархан Уул аймгийн Сагсан бөмбөгийн төрөлд гадаадын 6 дасгалжуулагч ажиллаж байгаа бөгөөд Ажлын байрны төлбөрөөс чөлөөлүүлэх албан бичгийг Хөдөлмөр халамжийн ерөнхий газарт хүргүүлсэн.	100		70
26	Арга хэмжээ 5.6 Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үйл ажиллагааны хүрээнд Монголын хүүхдийн спортын өвөл, зуны VIII наадмын хүрээнд салбарын 30 байгууллагад наадамд оролцогч тамирчин хүүхдүүдийн аюулгүй байдлыг хангах, эрүүл мэндийн үзлэгт хамруулах, гэнэтийн ослын даатгалд заавал хамруулах, тэвээрлэх үеийн тээврийн хэрэгслийн аюулгүй байдлыг сайн хагсан байх чиглэлээр цахим сургалтыг 2 удаа зохиосон.	100		70
	Зорилт 6.1. Биеийн тамир, спортын салбарын хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, тайлагнах, салбарын хууль, эрх зүйн орчин боловсронгуй болгох, мэргэжил, арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх			
27	Арга хэмжээ 6.1.1 Холбогдох 3 удаагийн саналыг ССАЖЗЯаманд хүргүүлсэн. 1/.Олон улсын олимпын хорооны ивээл доор зохион байгуулагддаг тив, дэлхийн наадам болон дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчийг шагнаж урамшуулах, мөнгөн шагнал олгох журам, Үндэсний хэмжээний тэмцээн, наадамд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчийг шагнаж урамшуулах, мөнгөн шагнал олгох журмын шинэчлэлтэй холбоотойгоор 2021-2023 онуудад мөнгөн шагнал авсан тамирчдын судалгааг гаргаж, журмын төсөлд ССАЖЗЯаманд санал хүргүүлсэн. 2/. Дасгалжуулагчийн сургалтын хөтөлбөрийн төсөлд санал өгч, 21 аймаг, 9 дүүргийн биеийн тамир, спортын байгууллагын ажилтан, албан хаагч, спорт клуб, спортын холбоодоор хэлэлцүүлэн, ирүүлсэн 33 дэмжсэн саналыг 2025 оны 1/263 дугаар албан бичгээр ССАЖЗЯаманд хүргүүлсэн. 3/.Тайвань улсын Спортын холбооноос “Тэмцээн наадмын цахим бүртгэлийн систем” сэдвээр БТСУХ болон яамны цахим хэлстсийн мэргэжилтэнүүд сургалтад 2025,10,21-ний өдөр хамрагдаж, саналаа хүргүүлсэн.	100		70
28	Арга хэмжээ 6.1.2 Монголын иогчдын холбооноос боловсруулсан Иогийн стандартын төсөлд санал өгч, 21 аймаг, 9 дүүргийн биеийн тамир, спортын байгууллагын ажилтан, албан хаагч, спорт клуб, спортын холбоодоор хэлэлцүүлэн, ирүүлсэн саналыг ССАЖЗЯаманд 1/378 дугаар албан бичгээр хүргүүлсэн.	100		70

	Зорилт 6.2. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, харьяа байгууллагын удирдлагын үйл ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангах		
29	Арга хэмжээ 6.2.1 1/.Байгууллагын болон хэлтсийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд санал хүргүүлсэн. 2/.Хэлтсийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2025 оны 03 дугаар сарын 03-нд байгууллагын даргаар, мэргэжилтнүүд 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр тус тус баталсан. 3/.Хэлтсийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг улирал, жилээр тухай бүр тайлагнасан.	100	70
30	Арга хэмжээ 6.2.2 21 удаагийн үйл ажиллагаа: 1/.Авлигатай тэмцэх тухай хуулийн хүрээнд албан хаагч тус бүр Албан тушаалтны “2024 оны” хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгээ цахимаар бөглөн, баталгааны маягтыг хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэнд хуулийн хугацаанд өгсөн. 2/.Монгол улсад 2025 онд болох тэмцээний жагсаалтын нэгтгэлийг гаргасан. 3/.Спортын холбоодоос ирүүлсэн тэмцээний саналыг үндэслэн гадаад улсад 2025 онд зохиогдох тэмцээний жагсаалтын нэгтгэлийг гаргасан. 4/.Хэлтсийн үйл ажиллагааны 2025 оны 02 дугаар сарын тайлант мэдээг мэргэжилтэн Д.Мөнхбаяр, 03 дугаар сарын тайлант мэдээг мэргэжилтэн М.Наранбадрах нэгтгэн ССАЖЗЯаманд хүргүүлсэн. 5/.Хэлтсийн үйл ажиллагааны зарцуулсан зардлын сар бүрийн мэдээг нэгтгэж СХОХэлтэст цаг хугацаанд нь хүргүүлсэн. 6/.Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.27 дахь хэсгийг хэрэгжүүлэх хүрээнд Татварын ерөнхий газрын 2025.01.16 өдрийн 05/183 тоот мэдээлэл ирүүлэх тухай албан бичгийн дагуу Монгол Улсын Сагсан бөмбөг, Волейбол, Хоккей, Хөл бөмбөгийн дээд лигийн баг, клуб, тэдгээрийн эзэмшигч этгээдийн мэдээллийг нэгтгэж хүргүүлсэн. 7/. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Хаврын мод тарих арга хэмжээнд Биеийн тамир,спортын улсын хорооны даргын 2025 оны А/131 дүгээр тушаалаар Биеийн тамир, спортын улсын хорооны алба хаагчид болон Спортын ангаах ухаан, эрдэм шинжилгээний төв, Үндэсний шигшээ баг, Спортын холбоодын төлөөлөл нийт 159 хүний бүрэлдэхүүнтэйгээр 2025 оны 5 дугаар сарын 10-ны өдөр Налайх дүүргийн “Шинэ Налайх” цэцэрлэгт хүрээлэнд 2240 ширхэг хайлаас мод тарьсан. 8/.Засгийн газрын тогтоолын хавсралтаар батлагдсан “Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах журам”-ын хүрээнд зохион явагдсан спортын наадамд оролцсон 10 аймгийн тамирчдын үр дүнг нэгтгэж ССАЖЗЯаманд хүргүүлсэн. 9/.Биеийн тамир, спортын тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан олон нийтэд болон төрийн байгууллагуудад 2025.01.09-ний өдрийн 15:00 цагаас танилцуулах танилцуулгыг (СБХХ-ийн	100	70

хамаарах хуулийн заалт тус бүрээр) нэгтгэж хүргүүлсэн. 10/. Аймаг, нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын газар, хороодоос спортын дасгалжуулагч, арга зүйчээр ажиллаж байгаа орон тооны болон орон тооны бус албан хаагчдын судалгааг аван нэгтгэн 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдөр ССАЖЗЯ-нд хүргүүлсэн. 11/. Хэлтсийн чиг үүрэгтэй холбоотойгоор гаднаас нийт 613 албан бичгийг хүлээн авснаас 580 шийдвэрлэж, 33 бичиг судлагдаж байна. 12/. Хэлтсийн үйл ажиллагаатай холбоотойгоор гадны байгууллага, иргэнд нийт 186 албан бичгийг баталгаажуулан хүргүүлэн ажилласан. 13/. Байгууллагын бусад нэгжүүдэд Дотоод албан бичиг 13 явуулж, 8 дотоод албан бичгийг хүлээн авч, хариуг заасан хугацаанд хүргүүлэн хамтран ажилласан. 14/. Тус хэлтсээс байгууллагын албан хаагчдад 8 удаагийн мэдээллийг ег-д байршуулж мэдээллээр ханган хамтран ажилласан. 15/. Хэлтсийн хамт олон төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх ажлын хүрээнд 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдөр хуваарийн дагуу ажилласан. 16/. Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны Үнэлгээний хороо байгуулах тухай А/40 дугаар тушаалаар Үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар Д.Мөнхбаяр томилогдож Монголын хүүхдийн спортын зуны VIII наадмын медаль захиалгын бараа нийлүүлэгчийн гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан. 17/. Монгол Улсын ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэсний хөдөлгөөний хүрээнд намрын мод тарих ажиллагаанд Шинэ Налайх дүүргийн цэцэрлэгт хүрээлэнд 2025 оны 10 сарын 27-ны өдөр мод тарьсан. 18/. Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны Үнэлгээний хороо байгуулах тухай А/263 дугаар тушаалаар Үнэлгээний хорооны даргаар Д.Мөнхбаяр томилогдож XVII.2.1.13 дугаартай спорт заалны барилга (Говь-Алтай, Цогт сум, Баянтоорой тосгон)-ын Ажил гүйцэтгэх тендер сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан. 19/. Хэлтсийн хамт олон Дархан-Уул аймагт 2025 оны 10 дугаар сарын 09-12-ны өдрүүдэд зохиогдсон Биеийн тамир, спортын салбарын зөвлөгөөн, Багшийн хөгжлийн төвд зохиогдсон Салбар зөвлөгөөн, Спортын тэмцээн, наадам, олимпын бэлтгэл сургуулилт сэдэвт сургалтын зохион байгуулалтад ажиллан, хамрагдсан. 20/. Спортын холбоодоос ирүүлсэн тэмцээний саналыг үндэслэн дотоод, гадаад улсад 2026 онд зохиогдох тэмцээний жагсаалтыг нэгтгэсэн. 21/. Монголын Үндэсний спортын наадмыг 2026 онд Зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2025 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн А/357 дугаар тушаалаар батлуулж, Зохион байгуулах ажлын хэсгийн анхны хурлыг 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 11:00 цагт хийн “Монголын Үндэсний спортын		
--	--	--

	VIII наадмын өвлийн төрлийн шигшээ тэмцээний нэгдсэн зааврыг боловсруулж, батлуулсан.		
31	Арга хэмжээ 6.2.3 1/.Мэргэжилтэн Э.Хүрэлчулуун нь Удирдлагын академийн Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 2024 оны 09 дугаар сарын 20-ны өдрөөс 2025 оны 01 дүгээр сарын 31-ний хугацаанд хамрагдан амжилттай төгсөж Сертификат авсан. 2/.Мэргэжилтэн Д.Мөнхбаяр нь Удирдлагын академийн Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрөөс 04 дүгээр сарын 22-ыг хүртэлх хугацаанд хамрагдаж, Удирдлагын академийн захирлын 2025 оны А/249 тоот тушаалаар сертификат авсан. 3/.Мэргэжилтэн М.Наранбадрах, Э.Хүрэлчулуун нар А3 сургалтад 2025,04,03-04-нд хамрагдсан.	100	70
	Зорилт 6.3.Бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, тайлагнах, эрх зүйн орчин боловсронгуй болгох, мэргэжил, арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх		
32	Арга хэмжээ 6.3.1 Монголын хүүхдийн спортын өвөл, зуны VIII наадам, Монголын бүх ард түмний 16 наадмын хөтөлбөрт оролцогч тамирчдыг ялгаварлан гадуурхахгүйгээр тэгш оролцоог ханган ажилласан.	100	70
